



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/137


Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар бүлгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр Рашаант, Хужирын хяр, Дааган толгой Эмээлтийн хэсгийн хур хог хаягдлыг цэвэрлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар шинэчлэл ХХК нарын хооронд 2019 онд байгуулсан 2019-01/92-01 дугаар гэрээний дагуу Хур хог хаягдлыг цэвэрлэх ажилд шаардагдах 77.500.000. /Далан долоон сая таван зуун мянган/ төгрөгийг Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт олон жил хуримтлагдсан хур хог хаягдлыг цэвэрлэж, дахин үүсгэхгүй байх арга хэмжээг авах зардлаас гүйцэтгэлээр санхүүжүүлж Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын дансанд шилжүүлэхийг Ахлах нягтлан бодогч Б.Цэрмаад зөвшөөрсүгэй.

2. Дээр дурдсан ажлын захиалагчийн хяналт тавьж ажилласан хөндлөнгийн хяналтын Төрийн бус байгууллагын санхүүжилтийг батлагдсан төсвийн 2%-аар тооцож олгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  С.ГАНТӨМӨР

